

БОЛОВСРОЛЫН САЛБАРТ ОНЦГОЙ БАЙДЛЫН АРГА ХЭМЖЭЭ СУЛРУУЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ

Боловсролын, залуучуудын ба спортын яам нь сүүлийн өдрүүдэд эрүүл мэндийн яамтай ба тахал судлагчидтай боловсролын салбарт онцгой байдлын арга хэмжээ сулруулах талаар хамтран ажиллаж байсан, энэ нь нийт улс даяар онцгой байдал сулруулах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болж байна. Энэ жилд хязгаарлагдсан горимд сургуульд буцах боломжтой сурагчид нь ялангуяа улсын, бакалаврын, төгсөлтийн, эцсийн ба абсолюторийн шалгалт өгөх оюутнууд нь болно. Дараа нь бас суурь сургуулийн бага ангийн сурагчид нь сайн дурын үндсэн дээр сургуулиудад буцаж болно. Бусад сурагчид нь зарим мэргэжлийн тусгай сургуулиудын сурагчид нь энэ сургуулийн жил дуусах хүртэл ихэнх хэмжээгээр сургуульд явахгүй болно. Энэ цагийн хуваарь нь Чех Улсад байгаа орчин цагийн эпидемиологийн ерөнхий байдлыг анхаарч, эрүүл мэндийн яамны ба засгийн газрын онцгой байдал сулруулах арга хэмжээнүүдийн бүрэлдэхүүн хэсэг болно. Эпидемиологийн байдлын хөгжилтийг анхаарч шинэчлэгдэх буюу нэмэгдэх болно. Аажмаар давтан сургах, хэлний боловсрол, зуны лагерь ба албан бус боловсролтой (дугуйлангууд) холбоотой мэдээллүүд нь тодотгодох болно.

5-р сарын 11-ээс эхлэж 9-р ангийн сурагчид сургуульд явж болно, тэд нар дунд сургуулийн элсэлтийн шалгалтанд бэлтгэх зорилготой болно. Дээр дурдсан сурагчдын ирц нь заавал байх албагүй, тэд нар хамгийн ихдээ 15 хүний тоотой бүлгэмд суралцах болно.

Урлагийн үндсэн сургуульд, төрийн хэлний шалгалт авах эрхтэй хэлний сургуульд ба өдөр тутмын сургалттай гадаад хэлний нэг жилийн курсад сургалт явуулахад нь сурагчид биечлэн оролцож болно. Дахин давтаж хэлэхэд сургалт нь хамгийн ихдээ 15 хүний тоотой бүлгэмд явуулагдах болно.

5-р сарын 11-нд бас чөлөөт цагийн төвд (*хамгийн ихдээ 15 хүний тоотой бүлгэмүүд*), сургуультай өнчин хүүхдийн газарт, боловсролын ба оношилгооны хүрээлэнд, түүнээс гадна бас эрүүл мэндийн байгууламжийн сургуулиудад үйл ажиллагааг сэргээж явуулагдана. Сургуулийн зөвлөгөө өгөх байгууламж (жишээлвэл, сурган хүмүүжүүлэх-сэтгэл зүйн зөвлөгөөний газар, тусгай сурган хүмүүжүүлэх төвд) үйл ажиллагаа нь бас эхлэх болно.

5-р сарын 25-аас эхлэж суурь сургуулийн анхан шатны сурагчид нь сургуулийн бүлгэмийн боловсролын үйл ажиллагаанд биечлэн оролцож болно. Гэвч сурагчид энд заавал оролцож байх үүрэггүй. Сурган хүмүүжүүлэх ажилтнууд ба бусад ажилтнуудын эрсдлийн бүлгийн хамгаалалт явуулах хүрээн дотор, түүнээс гадна сурагчид ба тэдний гэр бүлийнхнийг хамгаалахын төлөө цаашдаа ч гэсэн алсын зайн сургалт явуулагдах болно.

- *Сургуулийн бүлгэмд санал болгосон сурагчдын тоо нь 15 хүнтэй бөгөөд орон нутгийн нөхцлийн дагуу энэ тоо ихэсгэж болно, гэвч нэг ширээнд нэг сурагч байх ёстой гэдэг нөхцөл биелүүлэх ёстой.*
- *Бүлгэмийн бүрэлдүүлбэр өөрчлөгдөхгүй бөгөөд хүүхэд нь бүлгэмээ сольж болохгүй. Бүлгүүдийн харилцах холбоо нь хязгаарлагдмал байх болно.*
- *Сургуулийн бүлгүүд, сургуулийн клубууд ба сонирхлын дугуйлангууд нь нэг бүлгэмийн хүрээний тоо баримтлаж үүнийг хэтрүүлж болохгүй.*
- *Биеийн тамирын хичээлийг хориглоно.*

- *Хоолны өрөөний хувьд, шуурхай эпидемиологийн байдлаас ба орон нутгийн нөхцлөөс болж ажиллах болно, ялангуяа бие даасан бүлгүүдийг салгах боломжийг харгалзах болно.*
- *Сургалтын үед амны хаалтыг зүүх тухай зөвлөгдөж байна, гэвч багш нь хэрэгцээний дагуу амны хаалтыг зүүх/үгүй тухай шийдвэрлэх эрхтэй. Бүлгэмийн ажилд ба хоорондоо ойрон үйл ажиллагаа явуулахад, бас ангийн гадуур ба сургуулийн нийтлэг газарт явахдаа амны хаалтыг зүүх үүрэгтэй.*

2020 оны 6-р сар – Хэрвээ эпидемиологийн байдал зөвшөөрвөл, суурь сургуулийн 2-р шатны ба дунд сургуулийн сурагчдад зөвлөлгөө өгөх ба үе үе боловсролын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч болно.

6-р сард дунд сургуулиудад жигд ба сургуулийн элсэлтийн шалгалтыг хэрэгжүүлэх боломжтой болно гэж бодогдож байна.

Иш татсан: <http://www.msmt.cz/harmonogram-uvolnovani-opatreni-v-oblasti-skolstvi>

Шинэчлэгдсэн: 2020 оны 5-р сарын 4-нд